



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2005 оны дөрөвдүгээр сарын 29

№16 (397)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

678. Азийн авто замын сүлжээний тухай Засгийн газар
хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай 358

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

679. Бүгд Найрамдах Сингапур Улсад Элчин сайдын
яам байгуулах тухай Дугаар 27 358

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

680. Ноён Мадл Ференцийг сувдан шигтгээт
"Эрдэнийн Очир" одонгоор шагнах тухай Дугаар 62 358
681. Кара Дьёрдийг Хөдөлмөрийн гавъяаны улаан
тугийн одонгоор шагнах тухай Дугаар 63 358
682. Бямбын Жигжидэд Монгол Улсын аж үйлдвэрийн
гавъяат ажилтан цол хүртээх тухай Дугаар 64 358
683. Азадын Баатарцогтод хошууч генерал
цол хүртээх тухай Дугаар 65 359

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

684. Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл,
ажлын хэсгийн тухай Дугаар 66 359
685. Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй
холбогдсон зарим арга хэмжээний тухай Дугаар 67 369
686. Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөөний
тухай Дугаар 72 371
687. Хавсралтад нэмэлт оруулах тухай Дугаар 74 371
688. Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай Дугаар 75 371

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр

Улаанбаатар хот

**АЗИЙН АВТО ЗАМЫН СҮЛЖЭЭНИЙ ТУХАЙ
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ
СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. БНХАУ-ын Шанхай хотноо 2004 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр гарын үсэг зурсан Азийн авто замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг Монгол Улсын

Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД
ДАРГА****Д.ЛҮНДЭЭЖАНЦАН****МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2005 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

**Бүгд Найрамдах Сингапур Улсад
Элчин сайдын яам байгуулах тухай**

Дипломат албаны тухай хуулийн 6.4-ийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

сайдын яам болгон өөрчлөн зохион байгуулсугай.

Монгол Улсаас Бүгд Найрамдах Сингапур Улсад суугаа Ерөнхий консулын газрыг Элчин

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД
ДАРГА****Д.ЛҮНДЭЭЖАНЦАН****МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2005 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар 62

Улаанбаатар хот

**Ноён Мадл Ференцийг сувдан шигтгээт
"Эрдэнийн очир" одонгоор шагнах тухай**

Монгол Улс, Бүгд Найрамдах Унгар Улсын уламжлалт харилцаа, хамтын ажиллагааг өргөтгөн хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Бүгд Найрамдах Унгар Улсын Ерөнхийлөгч,

Эрхэмсэг ноён Мадл Ференцийг сувдан шигтгээт "Эрдэнийн очир" одонгоор шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ****Н.БАГАБАНДИ****МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2005 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар 63

Улаанбаатар хот

**Кара Дьердийг Хөдөлмөрийн гавьяаны
улаан тугийн одонгоор шагнах тухай**

Монгол Улс, Бүгд Найрамдах Унгар Улсын шинжлэх ухааны байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, монгол судлалыг хөгжүүлэх, монголч эрдэмтэн судлаачдыг бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Бүгд Найрамдах Унгар Улсын иргэн, монголч

эрдэмтэн Кара Дьердийг Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ****Н.БАГАБАНДИ****МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2005 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар 64

Улаанбаатар хот

**Бямбын Жигжидэд Монгол Улсын
аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай**

Дэд бүтцийн салбарт удирдах ажил олон жил санаачилга, үр бүтээлтэй хийж, салбарын хөгжлийг түргэтгэх, түүний эрх зүйн орчинг бүрдүүлэх, томоохон төсөл, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, хот, хөдөөгийн хүн амд дэд бүтцийн үйлчилгээг хүргэх үйлст оруулсан хувь нэмрийг нь

үнэлж Бямбын Жигжидэд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ****Н.БАГАБАНДИ**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр

Дугаар 65

Улаанбаатар хот

Азадын Баатарцогтод хошууч генерал цол хүртээх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай бөгөөд Хилийн цэргийн штабын дарга Азадын хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Баатарцогтод хошууч генерал цол хүртээсүгэй.

ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Хил хамгаалах ерөнхий газрын дэд дарга

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр

Дугаар 66

Улаанбаатар хот

Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

хоорондын худалдаа, хөрөнгө оруулалтын хамтарсан зөвлөлийн Монголын талын хэсгийн бүрэлдэхүүнийг 16 дугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

1. Гаалийн тарифын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 20.3, Эмийн тухай хуулийн 5.1, Аялал жуулчлалын тухай хуулийн 15.3, Садар, самуун явдалтай тэмцэх тухай хуулийн 9.2, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23.2, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 14.5, Төрийн албан ёсны хэлний тухай хуулийн 6.3, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 13³.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 11.2, Цэрэг, цагдаагийн албан хаагчийг НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай хуулийн 4.1.7-д заасныг үндэслэн Гаалийн тарифын зөвлөлийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, Стандартчилал, хэмжил зүйн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2 дугаар, Эмийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 3 дугаар, Аялал, жуулчлалын бодлого зохицуулах үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 4 дүгээр, Эротикийн сурталчилгаанд хяналт тавих үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 5 дугаар, Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 6 дугаар, Гамшигтай тэмцэх комиссын бүрэлдэхүүнийг 7 дугаар, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих байнгын зөвлөлийн бүрэлдэхүүнийг 8 дугаар, Төрийн хэлний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 9 дүгээр, Архидан согтуурахтай тэмцэх сангийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг 10 дугаар, "Мянганы зам" төслийг хэрэгжүүлэх үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 11 дүгээр, Тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 12 дугаар, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 13 дугаар, Архивын салбарт хамтран ажиллах Монгол Улс, ОХУ-ын хамтарсан комиссын Монголын хэсгийн бүрэлдэхүүнийг 14 дүгээр, Цэрэг, цагдаагийн багийг НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд бэлтгэх, оролцуулах асуудлыг зохицуулах үүрэг бүхий зөвлөлийн бүрэлдэхүүнийг 15 дугаар, Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын Засгийн газар

2. Засгийн газрын гишүүний эрхлэх ажлын хүрээнд үйл ажиллагаа явуулах орон тооны бус Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсэг болон тэдгээрийн даргыг 17 дугаар хавсралт ёсоор баталсугай.

3. Холбогдох сайд болон Засгийн газрын агентлаг, байгууллагын даргатай тохиролцсоны үндсэн дээр бүрэлдэхүүнээ шинэчлэн тогтоож ажиллахыг энэ тогтоолын 2 дугаар зүйлд заасан комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн дарга нарт үүрэг болгосугай.

4. Цаашид Засгийн газраас байнга ажиллах чиг үүрэг бүхий орон тооны бус комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсэг байгуулахдаа энэ тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэж байхыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Засгийн газрын комисс, Үндэсний зөвлөл, хороо, ажлын хэсгийн тухай" Засгийн газрын 2002 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 138 дугаар тогтоол, "Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай" Засгийн газрын 2002 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 149 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт, "Журам, бүрэлдэхүүн батлах тухай" Засгийн газрын 2003 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 177 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, "Хамтарсан зөвлөлийн Монголын хэсгийн бүрэлдэхүүнийг батлах тухай" Засгийн газрын 2004 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 91 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА

С.БАЯРЦОГТ

Засгийн газрын 2005 оны 66 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

ГААЛИЙН ТАРИФЫН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	-Сангийн сайд
Орлогч дарга	-Үйлдвэр, худалдааны дэд сайд
Гишүүд:	-Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга (тохиролцсоноор); -Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Улсын гаалийн ерөнхий газрын дарга; -Үндэсний татварын ерөнхий газрын дэд дарга; -Гадаад хэргийн яамны Гэрээ,эрх зүйн газрын захирал; -Сангийн яамны Эдийн засгийн нэгдсэн бодлогын газрын дарга; -Хууль зүй, дотоод хэргийн яамны Зохицуулалт, мэдээлэл, хяналт-шинжилгээний газрын дарга; -Батлан хамгаалах яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга; -Байгаль орчны яамны Стратеги төлөвлөлт, бодлого, зохицуулалтын газрын дарга; -Түлш, эрчим хүчний яамны Эдийн засаг, мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга; -Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны Эдийн засаг, хамтын ажиллагааны газрын дарга; -Барилга, хот байгуулалтын яамны Барилга, нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газрын дарга; -Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Нийгмийн хамгааллын бодлого, зохицуулалтын газрын дарга; -Хүнс, хөдөө аж ахуйн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга; -Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засаг, удирдлага төлөвлөлтийн газрын дарга; -Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга (тохиролцсоноор).
Нарийн бичгийн дарга	-Үйлдвэр, худалдааны яамны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлого, зохицуулалтын газрын дарга.

Засгийн газрын 2005 оны 66 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	-Стандартчилал, хэмжил зүйн төвийн дарга
Гишүүд:	-Улсын мэргэжлийн хяналтын газрын дэд дарга; -Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга; -Байгаль орчны яамны Стратеги төлөвлөлт, бодлого, зохицуулалтын газрын дарга; -Үйлдвэр, худалдааны яамны Үйлдвэрийн бодлого, зохицуулалтын газрын дарга; -Сангийн яамны Эдийн засгийн нэгдсэн бодлогын газрын дарга; -Хүнс, хөдөө аж ахуйн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга; -Эрүүл, мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга; -Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны Авто замын бодлого, зохицуулалтын газрын дарга; -Батлан хамгаалах яамны Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга; -Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Ерөнхий боловсролын хэлтсийн дарга; -Түлш, эрчим хүчний яамны Эрчим хүчний бодлого, зохицуулалтын газрын дарга; -Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн судалгааны төвийн дарга; -Мэдээлэл, хэрилцээ холбоо, технологийн газрын Бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга;

- Барилга, хот байгуулалтын яамны Барилга, нийтийн аж ахуйн хөгжлийг дэмжих төвийн дарга;
- Зэвсэгт хүчний жанжин штабын Цэргийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах албаны дарга;
- Шинжлэх ухааны академийн дэд ерөнхийлөгч;
- Үндэсний статистикийн газрын Мэдээлэл боловсруулалт, технологийн газрын дарга (тохиролцсоноор);
- Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын дэд дарга (тохиролцсоноор);
- Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдийн үндэсний холбооны дарга (тохиролцсоноор);
- Стандартчилал, хэмжил зүйн төвийн ажилтан (орон тооны).

Нарийн бичгийн дарга

Засгийн газрын 2005 оны 66 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

ЭМИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- | | |
|----------------------------------|--|
| Дарга
Орлогч дарга
Гишүүд: | <ul style="list-style-type: none"> -Эрүүл мэндийн дэд сайд -Хүнс, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн дарга -Сангийн яамны Төсвийн бодлого, зохицуулалтын газрын дарга; -Хууль зүй, дотоод хэргийн яамны Зохицуулалт, мэдээлэл, хяналт-шинжилгээний газрын дарга; -Үйлдвэр, худалдааны яамны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлого, зохицуулалтын газрын орлогч дарга; -Хүнс, хөдөө аж ахуйн яамны эмийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн; -Хүний эмийн салбар зөвлөлийн дарга; -Малын эмийн салбар зөвлөлийн дарга; -Улсын мэргэжлийн хяналтын газрын Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн хяналтын хэлтсийн дарга; -Улсын мэргэжлийн хяналтын газрын Эрүүл мэндийн хяналтын хэлтсийн дарга; -Эрүүл мэндийн стандартчиллын техникийн хорооны дарга; -Хөдөө аж ахуйн стандартчиллын техникийн хорооны дарга; -Монгол Улсын малын ерөнхий эмч. |
| Нарийн бичгийн дарга | -Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтсийн дарга. |

Засгийн газрын 2005 оны 66 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт

АЯЛАЛ, ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГО ЗОХИЦУУЛАХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- | | |
|----------------------------------|---|
| Дарга
Орлогч дарга
Гишүүд: | <ul style="list-style-type: none"> -Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд -Байгаль орчны сайд -Нийслэлийн Засаг даргын орлогч; -Сангийн яамны Төсвийн бодлого, зохицуулалтын газрын дарга; -Байгаль орчны яамны Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын дарга; -Аялал, жуулчлалын холбооны тэргүүн (тохиролцсоноор); -Аялал, жуулчлалын Мэдээллийн төвийн гүйцэтгэх захирал (тохиролцсоноор); -Зочид буудлуудын холбооны ерөнхийлөгч(тохиролцсоноор). |
| Нарийн бичгийн дарга | -Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны Аялал, жуулчлалын бодлого, зохицуулалтын газрын дарга. |

Засгийн газрын 2005 оны 66 дугаар
тогтоолын 5 дугаар хавсралт

ЭРОТИКИЙН СУРТАЛЧИЛГААНД ХЯНАЛТ ТАВИХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга Гишүүд:	-Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга -Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Соёл, урлагийн газрын дарга; -Эрүүл мэндийн яамны Мэдээлэл, хяналт- шинжилгээ, үнэлгээний газрын дарга; -Төрийн соёрхолт зохиолч Б.Догмид; -"Монгол кино" нэгтгэлийн ерөнхий захирал Ж.Солонго; -Соёл, урлаг судлалын хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга; -Нийслэлийн Соёл, урлагийн газрын дарга; -ДОХ-ын үндэсний төвийн захирал; -Монголын чөлөөт ардчилсан сэтгүүлчдийн эвлэлийн тэргүүлэгч (тохиролцсоноор).
Нарийн бичгийн дарга	-Хууль зүй, дотоод хэргийн яамны Зохицуулалт, мэдээлэл, хяналт- шинжилгээний газрын дарга.

Засгийн газрын 2005 оны 66 дугаар
тогтоолын 6 дугаар хавсралт

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга Орлогч дарга Гишүүд:	-Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд -Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд -Барилга, хот байгуулалтын сайд; -Үйлдвэр, худалдааны сайд; -Сангийн дэд сайд; -Зам, тээвэр, аялал жуулчлалын дэд сайд; -Хүнс, хөдөө аж ахуйн дэд сайд; -Эрүүл мэндийн дэд сайд; -Батлан хамгаалахын дэд сайд -Байгаль орчны дэд сайд; -Түлш, эрчим хүчний дэд сайд; -Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга; -Онцгой байдлын ерөнхий газрын тэргүүн дэд дарга; -Боловсролын хүрээлэнгийн захирал; -Стандартчилал, хэмжил зүйн төвийн стандартчилал, баталгаажилтын газрын дарга; -Монголын залуучуудын холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор); -Монголын эмэгтэйчүүдийн холбооны дэд дарга (тохиролцсоноор); -Ажил олгогч эздийн нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал (тохиролцсоноор); -Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын орлогч дарга (тохиролцсоноор); -Үйлдвэрлэл, үйлчилгээний хоршоодын холбооны тэргүүн (тохиролцсоноор); -Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны дэд ерөнхийлөгч (тохиролцсоноор);
Нарийн бичгийн дарга	-Мэргэжлийн боловсрол, сургалтын мэргэжил-арга зүйн төвийн захирал.

*Засгийн газрын 2005 оны 66 дугаар
тогтоолын 7 дугаар хавсралт*

ГАМШИГТАЙ ТЭМЦЭХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	-Онцгой байдлын асуудал эрхэлсэн Монгол Улсын сайд
Орлогч дарга	-Эрхлэх ажлын хүрээнд нь гамшиг болсон салбарын сайд; -Онцгой байдлын ерөнхий газрын дарга.
Гишүүд:	-Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Хүнс, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Түлш, эрчим хүчний яамны Эрчим хүчний төлөвлөлт, зохицуулалтын хэлтсийн дарга; -Зам, тээвэр, аялал жуулчлалын улсын албаны дарга; -Хэв журам сахиулах улсын албаны дарга; -Барилга, хот байгуулалтын улсын албаны дарга; -Сурталчилгаа, мэдээллийн улсын албаны дарга; -Цацрагийн аюулаас хамгаалах улсын албаны дарга; -Мэргэжлийн хяналтын улсын албаны дарга; -Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын дарга; -Байгалийн болон химийн аюулыг үнэлж мэдээлэх улсын албаны дарга; -Нийслэлийн Засаг даргын орлогч; -Зэвсэгт хүчний Жанжин штабын иргэний хамгаалалтын хэлтсийн дарга; -Нутаг дэвсгэр дээр нь гамшиг болсон аймаг, сумын Засаг дарга.
Нарийн бичгийн дарга	-Онцгой байдлын ерөнхий газрын Шуурхай удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга.

*Засгийн газрын 2005 оны 66 дугаар
тогтоолын 8 дугаар хавсралт*

МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	-Эрүүл мэндийн сайд
Орлогч дарга	-Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд
Гишүүд:	-Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга (зөвшилцсөнөөр); -Байгаль орчны дэд сайд; -Боловсрол, соёл, шинжлэх ухааны дэд сайд; -Үйлдвэр, худалдааны яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Улсын гаалийн ерөнхий газрын дарга; -Улсын мэргэжлийн хяналтын газрын дарга; -Цагдаагийн ерөнхий газрын дарга; -Тануулын ерөнхий газрын дарга; -Хил хамгаалах ерөнхий газрын дарга; -Гадаад хэргийн яамны Олон талт хамтын ажиллагааны газрын захирал; -Эрүүл мэндийн яамны Эрүүл мэндийн бодлого, зохицуулалтын газрын дарга; -Хүнс, хөдөө аж ахуйн яамны Мал эмнэлгийн газрын дарга; -Сэтгэцийн эмгэг, наркологийн төвийн захирал.
Нарийн бичгийн дарга	-Эрүүгийн цагдаагийн газрын дэд дарга.

**Засгийн газрын 2005 оны 66 дугаар
тогтоолын 9 дүгээр хавсралт**

ТӨРИЙН ХЭЛНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга Гишүүд:	-Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд -Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Оюуны өмчийн газрын дарга; -Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга; -Үйлдвэр, худалдааны яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга; -Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл, сурталчилгааны үндэсний төвийн хуулийн нэр томъёоны асуудал хариуцсан газрын дарга; -Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга; -Шинжлэх ухааны академийн нийгмийн ухаан хариуцсан дэд ерөнхийлөгч; -МУИС-ын Монгол хэл, соёлын сургуулийн захирал; -Монгол Улсын боловсролын их сургуулийн Монгол судлалын сургуулийн захирал; -Төрийн хэлний зөвлөлийн ажлын албаны дарга.
Нарийн бичгийн дарга	-Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хурээглэнгийн захирал.

**Засгийн газрын 2005 оны 66 дугаар
тогтоолын 10 дугаар хавсралт**

**АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ САНГИЙН
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга Гишүүд:	-Хууль зүй, дотоод хэргийн сайд -Сэлэнгэ аймгийн Засаг дарга; -Эрүүл мэндийн дэд сайд; -Хүнс, хөдөө аж ахуйн дэд сайд; -Сангийн дэд сайд; -Үйлдвэр, худалдааны яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Нийслэлийн Засаг даргын орлогч; -Цагдаагийн ерөнхий газрын дарга; -Улсын мэргэжлийн хяналтын газрын дэд дарга; -Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга (тохиролцсоноор); -Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн тэргүүн (тохиролцсоноор); -"Улаанбаатар ротари клуб"-ийн ерөнхийлөгч (тохиролцсоноор); -Хүнс үйлдвэрлэгчдийн холбооны тэргүүн (тохиролцсоноор); -Монголын бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн холбооны тэргүүн (тохиролцсоноор).
Нарийн бичгийн дарга	-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга.

**Засгийн газрын 2005 оны 66 дугаар
тогтоолын 11 дүгээр хавсралт**

**"МЯНГАНЫ ЗАМ" ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга Орлогч дарга Гишүүд:	-Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд -Сангийн сайд -Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга; -Үйлдвэр, худалдааны дэд сайд; -Гадаад хэргийн дэд сайд; -Батлан хамгаалахын дэд сайд; -Байгаль орчны дэд сайд; -Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд; -Хүнс, хөдөө аж ахуйн дэд сайд; -Барилга, хот байгуулалтын дэд сайд; -Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
----------------------------------	--

- Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга;
- Цагдаагийн ерөнхий газрын Замын цагдаагийн газрын дарга.

*Засгийн газрын 2005 оны 66 дугаар
тогтоолын 12 дугаар хавсралт*

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	-Монгол Улсын Ерөнхий сайд
Орлогч дарга:	-Сангийн сайд; -Байгаль орчны сайд; -Үйлдвэр, худалдааны сайд.
Гишүүд:	-Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга (зөвшилцсөнөөр); -Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга (зөвшилцсөнөөр); -Улсын Их Хурлын Байгаль орчны байнгын хорооны дарга (зөвшилцсөнөөр); -Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга; -Онцгой байдлын асуудал эрхэлсэн Монгол Улсын сайд; -Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд; -Гадаад хэргийн сайд; -Хүнс, хөдөө аж ахуйн сайд; -Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд; -Барилга, хот байгуулалтын сайд; -НҮБ-д суугаа Монгол Улсын Байнгын төлөөлөгч, Элчин сайд; -Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч; -Эрүүл мэндийн дэд сайд; -Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Түлш, эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Ерөнхий сайдын эдийн засгийн бодлогын зөвлөх; -Хүүхдийн төлөө үндэсний газрын дарга; -Үндэсний статистикийн газрын Статистикийн төлөвлөлт, бодлого зохицуулалтын газрын дарга (тохиролцсоноор); -Шинжлэх ухааны академийн дэд ерөнхийлөгч; -Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захирал; -Монгол Улсын их сургуулийн Цөмийн энергийн төвийн захирал; -Тогтвортой хөгжлийн Бизнесийн зөвлөлийн дарга; -Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор); -Эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудын сүлжээний тэргүүн (тохиролцсоноор); -Монголын Байгаль орчны төрийн бус байгууллагуудын холбооны тэргүүн (тохиролцсоноор); -Монголын залуучуудын холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор).
Нарийн бичгийн дарга	-Байгаль орчны яамны Тогтвортой хөгжил, хүрээлэн буй орчны газрын дарга.

Засгийн газрын 2005 оны 66 дугаар
тогтоолын 13 дугаар хавсралт

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга
Орлогч дарга
Гишүүд:

- Монгол Улсын Ерөнхий сайд
 - Эрүүл мэндийн сайд
 - Байгаль орчны сайд;
 - Хүнс, хөдөө аж ахуйн сайд;
 - Батлан хамгаалахын сайд;
 - Үндэсний статистикийн газрын дарга (зөвшилцсөнөөр);
 - Ерөнхийлөгчийн Нийгмийн бодлогын зөвлөх (зөвшилцсөнөөр);
 - Ерөнхий сайдын Нийгмийн бодлогын зөвлөх;
 - Эрүүл мэндийн дэд сайд, Дархлаажуулалтын сангийн зөвлөлийн дарга;
 - Боловсрол, соёл, шинжлэх ухааны дэд сайд;
 - Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн дэд сайд;
 - Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд;
 - Түлш, эрчим хүчний дэд сайд;
 - Зам, тээвэр, аялал жуулчлалын дэд сайд;
 - Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Үйлдвэр, худалдааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Онцгой байдлын ерөнхий газрын дарга;
 - Улсын мэргэжлийн хяналтын газрын дарга;
 - Стандартчилал, хэмжил зүйн төвийн дарга;
 - Нийслэлийн Засаг даргын орлогч;
 - Гадаад хэргийн яамны Олон талт хамтын ажиллагааны газрын захирал;
 - Батлан хамгаалах яамны Зэвсэгт хүчний Жанжин штабын Ар талын газрын дарга;
 - Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуулийн захирал;
 - Монголын улаан загалмай нийгэмлэгийн дэд ерөнхийлөгч (тохиролцсоноор);
 - Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн гүйцэтгэх захирал (тохиролцсоноор);
 - Эрүүл мэндийн ажилтны Үйлдвэрчний холбооны тэргүүн (тохиролцсоноор).
- Нарийн бичгийн дарга-Эрүүл мэндийн яамны Эрүүл мэндийн бодлого, зохицуулалтын газрын дарга

Засгийн газрын 2005 оны 66 дугаар
тогтоолын 14 дүгээр хавсралт

АРХИВЫН САЛБАРТ ХАМТРАН АЖИЛЛАХ МОНГОЛ УЛС, ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ХАМТАРСАН КОМИССЫН МОНГОЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга
Гишүүд:

- Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд
- Үндэсний архивын газрын дарга;
- Гадаад хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга;
- Үйлдвэр, худалдааны яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга;
- Шинжлэх ухааны академийн Түүхийн хүрээлэнгийн захирал;
- Үндэсний төв архивын захирал;
- Зэвсэгт хүчний төв архивын дарга;
- Засгийн газрын архивын эрхлэгч;
- Үндэсний архивын газрын судалгаа, арга зүй, хяналтын хэлтсийн дарга.

Засгийн газрын 2005 оны 66 дугаар
тогтоолын 15 дугаар хавсралт

**ЦЭРЭГ, ЦАГДААГИЙН БАГИЙГ НҮБ-ЫН ЭНХИЙГ САХИУЛАХ
БОЛОН ОЛОН УЛСЫН БУСАД АЖИЛЛАГААНД БЭЛТГЭХ,
ОРОЛЦУУЛАХ АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ҮҮРЭГ
БҮХИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга	-Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга
Орлогч дарга	-Гадаад хэргийн яамны Олон талт хамтын ажиллагааны газрын захирал
Гишүүд:	-Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга; -Сангийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга; -Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга; -Зэвсэгт хүчний Жанжин штабын Энхийг сахиулах газрын дарга; -Улсын гаалийн ерөнхий газрын дэд дарга; -Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга; -Иргэний нисэхийн ерөнхий газрын дэд дарга; -Татнуулын ерөнхий газрын Дүн шинжилгээ, мэдээлэл, судалгааны төвийн дарга.
Нарийн бичгийн дарга	-Батлан хамгаалах яамны Бодлого төлөвлөлт, гадаад хамтын ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн.

Засгийн газрын 2005 оны 66 дугаар
тогтоолын 16 дугаар хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, АНУ-ЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН ХУДАЛДАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХАМТАРСАН
ЗӨВЛӨЛИЙН МОНГОЛЫН ТАЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга	-Үйлдвэр, худалдааны сайд;
Гишүүд:	-Гадаадын хөрөнгө оруулалтын газрын орлогч дарга; -Улсын гаалийн ерөнхий газрын хяналт шалгалт хариуцсан дэд дарга; -Үндэсний статистикийн газрын Аргачлал, судалгааны газрын дарга (тохиролцооноор); -Гадаад хэргийн яамны Америк, Ойрхи дорнод, Африкийн газрын захирал; -Сангийн яамны Эдийн засгийн нэгдсэн бодлогын газрын дарга; -Сангийн яамны Зээл, тусламжийн нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга; -Хууль зүй, дотоод хэргийн яамны Зохицуулалт, мэдээлэл, хяналт-шинжилгээний газрын дарга; -Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны Эдийн засаг, хамтын ажиллагааны газрын дарга; -Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны Аялал, жуулчлалын бодлого, зохицуулалтын газрын дарга; -Түлш, эрчим хүчний яамны Эрчим хүчний бодлого, зохицуулалтын газрын дарга -Батлан хамгаалах яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга; -Монгол банкны Валютын газрын захирал (тохиролцооноор); -Түлш, эрчим хүчний яамны Хамтын ажиллагааны хэлтсийн дарга; -Хүнс, хөдөө аж ахуйн яамны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга; -Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Санхүү, эдийн засаг, төлөвлөлтийн хэлтсийн дарга; -Байгаль орчны яамны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга; -Эрүүл мэндийн яамны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга; -Онцгой байдлын ерөнхий газрын Тамгын газрын дарга; -Үндэсний татварын ерөнхий газрын Татварын удирдлага, арга зүйн хэлтсийн дарга; -Стандартчилал, хэмжил зүйн төвийн Стандартчилал, тохирлын үнэлгээний газрын стандартчиллын менежер;
Нарийн бичгийн дарга	-Үйлдвэр, худалдааны яамны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлого, зохицуулалтын газрын Америкийн Нэгдсэн Улс хариуцсан мэргэжилтэн.

Засгийн газрын 2005 оны 66 дугаар
тогтоолын 17 дугаар хавсралт

ЗАСГИЙН ГАЗРЫН КОМИСС, ҮНДЭСНИЙ ХОРОО, АЖЛЫН ХЭСЭГ, ТЭДГЭЭРИЙН ДАРГА

№	Комисс, үндэсний хороо, ажлын хэсэг	Дарга
1.	НҮБ-ын Хүнс тэжээл, хөдөө аж ахуйн байгууллагын асуудал эрхэлсэн Монголын комисс	Хүнс, хөдөө аж ахуйн сайд
2.	Д.Нацагдоржийн нэрэмжит шагнал эрхлэх комисс	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
3.	Монголын түүх, соёлын дурсгалт зүйлийг эрэн сурвалжлах, хадгалан хамгаалах асуудлыг эрхлэх улсын комисс	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
4.	Хилийн боомтын асуудал эрхэлсэн зөвлөл	Хууль зүй, дотоод хэргийн сайд
5.	Химийн хорт бодис ашиглах үйл ажиллагааг зохицуулах зөвлөл	Байгаль орчны сайд
6.	Үйлдвэрийн осол, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийн үр дагаврыг арилгах салбарт хамтран ажиллах Монгол-Оросын комиссын Монголын хэсэг	Онцгой байдлын асуудал эрхэлсэн Монгол Улсын сайд
7.	Улсын ургацын комисс	Хүнс, хөдөө аж ахуйн сайд
8.	Монголын ховор амьтныг хамгаалах үндэсний комисс	Байгаль орчны сайд
9.	НҮБ-ын Үйлдвэр хөгжлийн байгууллага /ЮНИДО/-ын Монголын үндэсний хороо	Үйлдвэр, худалдааны сайд
10.	НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага /ЮНЕСКО/-ын Монголын үндэсний комисс	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
11.	"Бүх нийтийн экологийн боловсрол" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах үндэсний зөвлөл	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
12.	Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үндэсний зөвлөл	Хүнс, хөдөө аж ахуйн сайд
13.	Усны үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үндэсний зөвлөл	Байгаль орчны сайд
14.	Ардын уламжлалт урлагийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үндэсний зөвлөл	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
15.	Хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үндэсний зөвлөл	Үйлдвэр, худалдааны сайд
16.	Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах улсын комисс	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
17.	Хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавих зөвлөл	Хууль зүй, дотоод хэргийн сайд
18.	Уур амьсгалын үндэсний хороо	Байгаль орчны сайд
19.	Хар тамхи, мансууралтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэсний хороо	Хууль зүй, дотоод хэргийн сайд
20.	Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулж хяналт тавих үндэсний зөвлөл	Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд
21.	Хулгайн гэмт хэргэтэй тэмцэх хөтөлбөрийн зөвлөл	Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд
22.	Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хороо	Ерөнхий сайд



23.	Улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөө боловсруулах бэлтгэлийг хангах ажлын хэсэг	Батлан хамгаалахын сайд
24.	Засгийн газрын худалдан авах ажиллагааны дунд хугацааны сургалтын хөтөлбөрийн үндэсний зөвлөл	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга
25.	Ой, мод боловсруулах салбарын үйлдвэрлэлийг сэргээх, тухайн чиглэлээр байгуулагдсан тосгоны хүн амын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үндэсний зөвлөл	Үйлдвэр, худалдааны сайд
26.	Монголын мэдээлэл, холбооны технологийн үндэсний хороо	Ерөнхий сайд
27.	Засгийн газар болон хувийн хэвшлийн хамтарсан зөвлөлдөх хороо	Үйлдвэр, худалдааны сайд, МҮХАУТ-ын дарга
28.	Дэлхийн худалдааны байгууллагын үйл ажиллагаа, худалдааны олон талт хэлэлцээнд Монгол Улсын баримтлах байр суурь, удирдамжийг боловсруулах, Монгол Улсын эрх ашгийн тусгалыг хангахад чиглэсэн хэлэлцээ хийхэд дэмжлэг үзүүлэх Засгийн газрын ажлын хэсэг	Үйлдвэр, худалдааны сайд
29.	Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөл	Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд
30.	Хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий үндэсний хороо	Хүнс, хөдөө аж ахуйн сайд
31.	Ойн тухай үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулах үндэсний хороо	Байгаль орчны сайд
32.	"Сонгодог урлаг" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын зөвлөл	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
33.	Хүн ам, хөгжлийн асуудлаархи үндэсний хороо	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд
34.	Дамжин өнгөрөх тээврийн асуудлыг зохицуулах үндэсний хороо	Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд
35.	Зүүн хойд Азийн орнуудын хамтын ажиллагааг бүс нутгийн хөгжлийн шинэ нөхцөл, шаардлагад нийцүүлэн идэвхжүүлэхэд дэмжлэг, тусалцаа үзүүлэх Засгийн газрын ажлын хэсэг	Сангийн сайд
36.	Биоаюулгүй байдлын асуудлыг зохицуулах үндэсний хороо	Байгаль орчны сайд
37.	Ховор ургамлын үндэсний зөвлөл	Байгаль орчны сайд

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр

Дугаар 67

Улаанбаатар хот

Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь;

байгууллагад амаар, бичгээр болон цахим сүлжээгээр ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх журмыг хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулж 2005 оны эхний хагас жилд багтаан баталж мөрдүүлсүгэй;

1. Сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгах нь:

а/иргэдээс яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, төрийн захиргааны бусад

б/иргэдээс амаар, бичгээр болон цахим сүлжээ, радио, телевизээр явуулж байгаа шууд



нэвтрүүлгээр, түүнчлэн тусгайлан ажиллуулсан утсаар дамжуулан ирүүлсэн өргөдөл, гомдлын талаар гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг шалгах, шийдвэрлэлтийн явцыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг нийтэд зарлан сурталчлах зэрэг ажлыг дээрх журамд тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авсугай;

в/Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдолд тусгагдсан асуудлуудыг өөрийн байгууллагын хэрэгжүүлэх бодлого, авах арга хэмжээнд тусган ажилласугай;

г/Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагад иргэдээс ирүүлсэн болон шийдвэрлүүлж хариу өгүүлэхээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас шилжүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийж, мэдээлэл, танилцуулга бэлтгэн улирал, хагас жилийнхийг 4, 7, 10 дугаар сарын 10-ны дотор, жилийн эцсийнхийг дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлж байсугай.

2. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулахтай холбогдуулан дор дурдсан арга хэмжээ авахыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар (С.БАЯРЦОГТ)-т үүрэг болгосугай:

а/Засгийн газарт иргэдээс амаар, бичгээр, цахим сүлжээгээр Засгийн газрын вэб сайтад ирүүлсэн өргөдөл, гомдлыг бүртгэн авч, судалж шийдвэрлэн хариу өгч, Засгийн газраас явуулж байгаа бодлого, шийдвэрийн талаархи ажил хэрэгч саналыг холбогдох яам, агентлаг, эрдэм шинжилгээ, судалгааны болон бусад байгууллагатай хамтран судалж дүгнэлт хийсний үндсэн дээр төр, засгийн бодлого, шийдвэрт тусгуулах арга хэмжээ авсугай;

б/Засгийн газарт иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын агуулга, бүтэц, чиг хандлага, шийдвэрлэлтэд судалгаа хийж, тойм танилцуулга, мэдээлэл бэлтгэн Засгийн газрын гишүүдэд сар бүр, Засгийн газрын хуралдаанд улирал, хагас, бүтэн жилээр танилцуулан нийтэд мэдээлж байсугай;

в/Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлэх талаар төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагуудыг арга зүйн удирдлагаар хангаж байсугай;

г/Иргэдээс төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдолд тусгагдсан асуудлуудыг тухайн байгууллагаас явуулах бодлого, авах арга хэмжээнд тусгасан байдалд хяналт тавьж байсугай;

д/Шийдвэрлүүлж хариу өгүүлэхээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас уламжилсан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавьж, төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн мэдээллийг нэгтгэн дүн шинжилгээ хийж, санал, дүгнэлт бэлтгэн Засгийн газрын хуралдаанд улирал, хагас, бүтэн жилээр танилцуулан нийтэд мэдээлэх, мөн яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт улирал тутам мэдээлж байсугай.

3. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаанд хамаарах асуудлаар иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд шилжүүлэн шийдвэрлүүлж, дүнг нэгтгэн улирал, хагас, бүтэн жилийн мэдээлэлд оруулж байхыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хуулийн хэрэгжилтийг зохион байгуулахтай холбогдсон зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1995 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн 222 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ц.ЭЛБЭГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА**

С.БАЯРЦОГТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр

Дугаар 72

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөөний тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт эрүүл мэндийн салбарын тогтолцоог шинэчлэх, эдийн засгийн шинэ харилцаанд нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг бий болгох талаар тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөө"-г сайшаасугай.

2. "Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөө"-г хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан

түүнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, нэгдсэн төсөвт тусгаж гадаад, дотоодын болон хувийн хэвшлийн байгууллагын хөрөнгө оруулалтыг татан оролцуулах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн сайд Т.Гандид даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**
Ц.ЭЛБЭГДОРЖ
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
Т.ГАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр

Дугаар 74

Улаанбаатар хот

Хавсралтад нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Засгийн газрын комисс, хороо, үндэсний

38.	Олимпын наадамд бэлтгэх үндэсний хороо	Монгол Улсын Ерөнхий сайд
-----	--	------------------------------

зөвлөл, ажлын хэсгийн тухай" Засгийн газрын 2005 оны 66 дугаар тогтоолоор баталсан 17 дугаар хавсралтад дараахь нэмэлт оруулсугай:

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Олимпын наадамд бэлтгэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2001 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 187 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийг

хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**
Ц.ЭЛБЭГДОРЖ
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
Т.ГАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр

Дугаар 75

Улаанбаатар хот

Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2005 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчныг сайжруулах Үндэсний хөтөлбөр (2005-2010 он)-ийг 1 дүгээр хавсралт ёсоор, хөтөлбөрийн нэгдүгээр үе шатыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ц.Баярсайхан, уг хөтөлбөрийг салбар, орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчныг сайжруулах үндэсний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, нэгдсэн төсөвт тусган санхүүжүүлж байхыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ц.Баярсайхан, Сангийн сайд Н.Алтанхуяг нарт даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 2001 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 153 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**
Ц.ЭЛБЭГДОРЖ
**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙД Ц.БАЯРСАЙХАН**

Засгийн газрын 2005 оны 75 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЭРҮҮЛ АХУЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын бага хурлын 2003 оны 91 дүгээр Чуулганаас хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлаархи дэлхий нийтийн стратегийн чиг шугамыг тодорхойлж, үндэсний хэмжээнд аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх зан үйлийг төлөвшүүлэхэд төрийн зүгээс онцгой анхаарал хандуулж, нийгмийн түншлэлийн зарчимд нийцсэн, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн менежментийн систем нэвтрүүлэхийг зөвлөж байгаа юм.

Монгол Улсын Засгийн газраас Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах хөтөлбөрийг 1997-2000, 2001-2004 оны хооронд 2 үе шаттайгаар хэрэгжүүлээ.

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн удирдлага, зохион байгуулалт, хяналтын тогтолцоог бүрдүүлэх, эрх зүйн орчинг сайжруулах, аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудалд зохих хэмжээнд анхаарах болсон зэрэг эерэг хандлага төлөвшиж байна.

Энэ хугацаанд Монгол Улс Олон улсын хөдөлмөрийн байгууллага (цаашид ОУХБ гэх)-ын Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, үйлдвэрлэлийн орчны тухай 155 дугаар конвенцид нэгдэн орсон бөгөөд Хөдөлмөрийн тухай хуульд хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандарттай холбоотой бүлгийг конвенцийн үзэл баримтлалтай нийцүүлсэн.

Улсын хэмжээнд явуулсан үзлэгийн дүнгээс үзэхэд 1000 хүнд ногдох үйлдвэрлэлийн осол, осолд өртсөн хүний тоо 1997-2004 оны хооронд 0.4 пунктээр тус тус буурсан байна.

Ийнхүү зарим нааштай ахиц өөрчлөлт байгаа боловч мэргэжлээс шалтгаалсан өвчний тоо төдийлэн буурсангүй. Энэ нь 20-30 жилийн өмнө ашиглалтад орсон үйлдвэрийн газрын ажлын байрны нөхцөл болон техник, тоног төхөөрөмжийн хоцрогдол, тухайн үйлдвэрт удаан хугацаагаар ажилласан ажиллагчдын өвчлөлийн оргил үе таарч байгаа зэрэг хүчин зүйл нөлөөлж байгаатай холбоотой байна.

Түүнчлэн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаархи олон чийтний ойлголтыг сайжруулахад чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийгдэхгүй, хөдөлмөрийн аюулгүй

ажиллагаа, эрүүл ахуйн асуудлаар үндэсний түвшинд шийдвэрлэж байгаа арга хэмжээний хоорондын уялдаа хангалтгүй байгаагийн зэрэгцээ үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг санхүүжүүлэх хөрөнгийн асуудлыг эрх зүйн хувьд зохицуулаагүй байна. Мөн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр тахир дутуу болж, хөдөлмөрийн чадвар алдсан иргэдэд зориулсан нөхөн сэргээх үйлчилгээ бий болгох, эдгээр иргэдийн мэргэжлийн чиглэлийг өөрчлөх, давтан сургалтад хамруулах талаар төдийлэн анхаарч чадахгүй байна.

Иймд дээрх асуудлыг зохицуулсан эрх зүйн орчны боловсронгуй болгох, энэ чиглэлийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн чадвар алдсанаас болж ажилтанд учирсан хохирлыг барагдуулах, хөдөлмөрийн чадвар алдалтыг нөхөн сэргээх, энэ талаархи мэргэжлийн сургалт, сурталчилгааны оновчтой тогтолцоо, эмчилгээ, үйлчилгээ бий болгох хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх шаардлагатай байна.

ОУХБ-ын зөвлөмж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн чиглэлээр тулгамдаж байгаа өнөөгийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчныг сайжруулах үндэсний хөтөлбөр /2005-2010/-ийг боловсруулсан болно.

Хөтөлбөрийг төр, засгийн бүх шатны байгууллага, нийгмийн түншлэлийн 3 тал, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтийн оролцоонод тулгуурлан улс, орон нутгийн хэмжээнд хөрөнгө, хүчний төвлөрүүлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар хэрэгжүүлэх болно.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар урьдчилан сэргийлэх зан үйлийг бий болгох, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг бууруулах, хөдөлмөрлөх үйл ажиллагааны явцад ажилтны эрүүл мэнд, амь насыг хамгаалах бүх нөхцөлийг бүрдүүлэх, ажилтныг мэргэжлийн эрсдэлээс хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох нийгмийн баталгааны түвшинг нэмэгдүүлэх, нийгмийн түншлэлийн механизмыг хөгжүүлэхэд чиглэгдэнэ.

Гурав. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаа, санхүүжилт

Хөтөлбөрийг 2010 он хүртэл хэрэгжүүлэх бөгөөд үйл ажиллагааг дараахь үе шатаар төлөвлөнө. Үүнд:

Нэгдүгээр үе шат 2005-2007;

Хоёрдугаар үе шат 2007-2010.

Хөтөлбөрийн санхүүжилтийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

а/улс, орон нутгийн төсвөөс олгох хөрөнгө;

б/хандивлагч орон, олон улсын байгууллагын тусламж, хандив;

в/төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын санаачилгаар хуримтлагдсан хөрөнгө;

г/гадаад, дотоодын хөрөнгө оруулалт;

д/бусад эх үүсвэр.

Дөрөв. Хөтөлбөрийн үйл ажиллагааны үндсэн чиглэл

Зорилт 1

Хөдөлмөрийн хүрээний суурь зарчим, үндсэн эрхүүдийн тухай ОУХБ-ын тунхаглалыг хэрэгжүүлэх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн эрх зүйн орчныг ОУХБ-ын конвенцитай нийцүүлэн боловсронгуй болгосноор дараахь үр дүнд хүрнэ.

Үр дүн: 1.1.

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн эрх зүйн орчныг боловсронгуй болгож, энэ талаархи ажил олгогч, ажилтан, олон нийтийн ойлголт сайжирна.

Үйл ажиллагаа:

1.1.1. ОУХБ-ын Аж үйлдвэр, худалдаан дахь хөдөлмөрийн байцаан шалгах газрын тухай 81, Хөдөлмөрийн эрүүл ахуйн албаны тухай 161, Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл дэх хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны 184 дүгээр конвенциудад нэгдэн орох арга хэмжээ авах;

1.1.2. Барилгын салбар дахь Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн 167, Уул уурхай

дахь Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн 176 дугаар Конвенциудад нэгдэн орох асуудлыг судлах;

1.1.3. ОУХБ-ын 155 дугаар Конвенцийг үндэсний хууль тогтоомжид нийцүүлэх үндсэн дээр уг конвенцийн хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авах;

1.1.4. ОУХБ-ын 155 болон бусад конвенциудын хэрэгжилтийн талаархи тайлан илтгэлийг тогтмолжуулж, Улсын Их Хурал, Хүний эрхийн үндэсний комисст танилцуулах, олон нийтэд мэдээлж хэвшүүлэх;

1.1.5. ОУХБ-ын 155 дугаар конвенцийг хэвлэн нийтлэх, сурталчлах үйл ажиллагааг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах;

1.1.6. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн үйлдвэрлэлийн орчны тухай ОУХБ-ын 155 дугаар конвенцийн талаархи сургалт, сурталчилгааг хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах.

Зорилт 2

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх асуудлын талаархи эрх зүйн орчныг бүрдүүлж, түүний хэрэгжилтийг хангаснаар дараахь үр дүнд хүрнэ.

Үр дүн: 2.1.

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх эрх зүйн зохицуулалт бий болж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөл буурсан байна.

Үйл ажиллагаа:

2.1.1. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаархи харилцааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хүрээнд уг асуудлаар бие даасан хууль гаргах үндэслэл, шаардлагыг судлан тодорхойлох арга хэмжээ авах;

2.1.2. Нийгмийн даатгалын сангаас олгох Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг боловсруулах;

2.1.3. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогоос урьдчилан

сэргийлэх дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;

2.1.4. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартыг шинээр болон шинэчлэн боловсруулж, мөрдүүлэх;

2.1.5. ОУХБ-ын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн удирдлагын системийн удирдамж (ILO-OSH 2001)-ийг үндэслэн аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн удирдлагын систем нэвтрүүлэх удирдамж боловсруулж, үе шаттайгаар хэрэгжүүлэх;

2.1.6. Уул уурхай, эрчим хүч, барилга, тээвэр, холбооны салбарын машин, тоног төхөөрөмж, аюултай бодисын аюулгүй ажиллагааны дүрэм, журам, зааврыг шинээр болон шинэчлэн боловсруулж, мөрдүүлэх;

2.1.7. Аж ахуйн нэгж, байгууллагуудад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн аттестатчиллыг 2 үе шаттайгаар хийх ажлыг зохион байгуулах;

2.1.8. Эрсдэл өндөртэй аж ахуйн нэгжүүдэд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөл гарч байгаа шалтгаан нөхцөлийг судлан, нөхцөлийн үнэлгээний сертификат олгох асуудлыг судлан боловсруулах;

2.1.9. Хөдөө аж ахуйн салбар болон албан бус секторт ажиллагчдын хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах чиглэлээр ОУХБ-тай хамтран төсөл хэрэгжүүлэх;

2.1.10. Хөдөө аж ахуйн салбар, жижиг, дунд үйлдвэрлэл, албан бус сектор (гэрээрээ хөдөлмөр эрхлэгчид, эмэгтэйчүүд, хүүхэд, залуучууд, тахир дутуу хүмүүс, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, эмээг бүлгийн ажиллагчдын)-ын хамрагдах хүрээг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар тэдгээрт зөвлөлгөө үзүүлэх чадавхийг бэхжүүлэх арга хэмжээг ОУХБ-ын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх;

2.1.11. Хөдөлмөрийн нөхцөлийн судалгааны лабораторийг өргөтгөх талаар холбогдох арга хэмжээ авах.

Зорилт 3

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн мэдээллийн тогтолцоог бүрдүүлэн, судалгаа, шинжилгээний ажлыг хөгжүүлэн дараахь үр дүнд хүрнэ.

Үр дүн: 3.1.

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн статистик, мэдээллийн тогтолцоо бүрдэж, судалгаа, шинжилгээний ажил өргөжсөн байна.

Үйл ажиллагаа:

3.1.1. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх;

3.1.2. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэдэх мэдээллийн төвүүдийг мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбох боломжийг судлах;

3.1.3. Улсын хэмжээнд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийн талаархи мэдээ цуглуулах, дүн шинжилгээ хийх нэгдсэн аргачиллыг ОУХБ-ын дэмжлэгтэй боловсруулж, үг мэдээллийг төлөвлөлт хийх, шийдвэр гаргах үйл ажиллагаанд ашиглах;

3.1.4. ОУХБ-тай хамтран хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн тодорхой асуудлуудаар судалгаа хийх, тэдгээрийг шийдвэр гаргах үйл ажиллагааны үндэслэл болгох;

3.1.5. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн чиглэлээр ажиллаж байгаа эрдэмтэн, судлаачдыг оролцуулсан эрдэм шинжилгээний хамтлагийг Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийг түшиглэн байгуулах асуудлыг судлан хэрэгжүүлэх;

3.1.6. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар хийгдэж байгаа судалгаа, шинжилгээний ажил, энэ талаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн нэгдсэн сан бий болгох;

3.1.7. Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн чанар, техникийн үзүүлэлтийг шалгадаг болох талаар холбогдох арга хэмжээ авах.

Зорилт 4

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар ажил олгогч, ажилтны хэрэгцээнд нийцсэн мэдлэг олгох, энэ талаархи олон нийтийн ойлголтыг сайжруулж дараахь үр дүнд хүрнэ.

Үр дүн: 4.1

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалт, сурталчилгааны системтэй тогтолцоо бүрдсэн байна.

Үйл ажиллагаа:

4.1.1. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн үндсэн асуудлаар ашиглахад хялбар сургалтын материал, сургагч багш нарт зориулсан аргачлал, сургалтын хөтөлбөр боловсруулах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх үр чадварын сургалтыг ОУХБ-ын төслийн хүрээнд зохион байгуулах;

4.1.2. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээ, тэдгээртэй холбоотой асуудлыг шийдвэрлэх практик аргуудыг олж авахад чиглэгдсэн сургалтыг нийт ажилтан, ажил олгогчдыг ажлын байран дээр нь тасралтгүй хамруулах механизмыг бий болгох;

4.1.3. Эмзэг бүлгийн болон албан бус секторт ажиллагчдад зориулсан сургалтыг төслийн хүрээнд хэрэгжүүлэх;

4.1.4. Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны WISE, Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны POSITIVE хөтөлбөрийн сургалтад хамрагдах хүрээг нэмэгдүүлэх, сургалтын материалыг улам боловсронгуй болгон бага зардлаар өргөн хүрээг хамруулах боломжийг бүрдүүлэх;

4.1.5. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаархи ойлголтыг дунд сургуулиас эхлэн боловсролын бусад байгууллагуудад суралцаж байгаа хүмүүст олгох асуудлыг боловсруулж, шийдвэрлүүлэх;

4.1.6. Төрийн болон төрийн бус байгууллагын удирдах ажилтнууд, ажилчид, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн чиглэлээр ажиллаж байгаа хүмүүст гүнзгийрүүлсэн мэдлэг олгох сургалтыг хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоотой өргөжүүлэн, сургалтын түшиц газар бий болгох;

4.1.7. Жил бүрийн 4 дүгээр сарын 28-ны өдрийг Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын улмаас бэртсэн буюу амь нас нь үрэгдсэн ажилтны дурсгалыг хүндэтгэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

4.1.8. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн үндэсний 7 хоногийн компани ажил зохион байгуулж хэвшүүлэх;

4.1.9. Сургалтын материаллаг бааз бүхий аж ахуйн нэгж, байгууллагуудыг түшиглэн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн

асуудлаар зөвлөх болон дэмжин туслах үйлчилгээг зохион байгуулах арга хэмжээ авах;

4.1.10. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлаархи шаардлагатай мэдээллийг иргэдэд хүргэх боломжийг интернет, CD-ROM зэргийг ашиглан бүрдүүлэх;

4.1.11. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн тэргүүн туршлага нэвтрүүлэх, харилцан солилцох ажлыг зохион байгуулж, практик арга зүй бий болгох.

Зорилт 5

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн удирдлага, зохион байгуулалт, хяналтын зохистой тогтолцоо бүрдүүлнэ.

Үр дүн: 5.1.

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн удирдлагын бүтэц, зохион байгуулалт, хяналтын зохистой тогтолцоо боловсронгуй болно.

Үйл ажиллагаа:

5.1.1. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал эрхэлсэн орон нутгийн болон аж ахуйн нэгж, байгууллагын чиг үүргийг боловсронгуй болгож, ажилтнуудыг чадваржуулах арга хэмжээ авах;

5.1.2. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан болон тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг үнэлж, урамшуулах журам тогтоож, мөрдөх;

5.1.3. Төрийн болон олон нийтийн хяналтын зохистой хослол бүхий хөдөлмөрийн хяналтын үр ашигтай тогтолцоог бий болгох;

5.1.4. Хөдөлмөрийн хяналтын үр ашиг, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн техникийн туслалцааны хэрэгцээг тодорхойлох, хөдөлмөрийн байцаагчдын чадавхийг бэхжүүлэх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн чиглэлээр мэргэшүүлэх төслийг ОУХБ-тай хамтран хэрэгжүүлэх.

Зорилт 6

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн гурван талт түншлэлийн механизмыг үндэсний болон салбарын түвшинд бэхжүүлэх, орон нутаг дахь төлөөллийн байгууллагуудын чадавхи, нийгмийн түншлэлийн талаархи олон нийтийн

ойлголтыг сайжруулах замаар нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулна.

Үр дүн: 6.1.

Нийгмийн түншлэлийн гурван талт хамтын ажиллагаа өргөжинө.

Үйл ажиллагаа:

6.1.1. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн гурван талт үндэсний дэд хорооны чадавхийг бэхжүүлэх;

6.1.2. Аймаг, нийслэлийн түвшинд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн гурван талт салбар хороодыг байгуулж, бэхжүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авах;

6.1.3. Аж ахуйн нэгж, байгууллагын хамтын гэрээ хэлэлцээрт хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн менежментийн систем нэвтрүүлэх асуудлыг тусгаж байх;

6.1.4. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн механизмыг хөгжүүлэх талаар олон нийтийн ойлголтыг сайжруулахад чиглэсэн сургалт, сурталчилгаа, хэвлэн нийтлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх.

Тав. Хөтөлбөрийн үр дүн, хяналт-шинжилгээ, үнэлгээ

Хөтөлбөрийн үр дүн:

1. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаархи ажил олгогч, ажилтны хүлээх үүрэг хариуцлагын эрх зүйн зохицуулалт бий болсон байна.

2. Хөдөлмөрийн нөхцөл болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, түүнийг зохион байгуулах арга хэмжээний санхүүжилтийн эрх зүйн зохицуулалт бий болж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөл буурсан, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл сайжирсан байна.

3. Засгийн газар, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллага, ажил олгогчид болон хөдөлмөрчдийн байгууллага, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн бодлого, үйл ажиллагаа

уялдсан, тэдгээрийн чиг үүрэг, хариуцлага, эрх хэмжээг тогтоосон удирдлагын нэгдсэн тогтолцоо бий болсон байна.

4. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн менежментийг нэвтрүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжин туслах хөтөлбөр хэрэгжиж, зохих үр дүнд хүрсэн байна.

5. Мэргэжлийн болон олон нийтийн хяналтыг зохистой хослуулсан хөдөлмөрийн хяналтын үр ашигтай, уян хатан тогтолцоо бүрдсэн байна.

6. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн холбогдолтой статистикийн мэдээллийг холбогдох мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагаа болон олон нийтийн оролцсонд тулгуурлан гаргадаг болж, статистик мэдээллийн хүртээмж, чанарыг сайжруулан, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн үйл ажиллагааны үндсэн илтгэлийг жил бүр гаргадаг болсон байна.

7. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн холбогдолтой сургалт болон судалгаа, шинжилгээний ажлын эхлэл тавигдсан, судалгааны байгууллагын чадавхи нь бэхжсэн байна.

8. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалт, сурталчилгааны ажилд хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоо өргөжиж, сургалтын танхим, мэргэжлийн боловсон хүчний нөөц бий болсон байна.

Хөтөлбөрийн хяналт- шинжилгээ, үнэлгээ:

Хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхлэн гүйцэтгэнэ. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилд төрийн бус байгууллага, иргэдийг өргөнөөр оролцуулж байна.

Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго нь хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг хангах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, туршлага, сургамжийг нэгтгэн дүгнэх, хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг санхүүжүүлэгчдэд тайлагнах, шаардлагатай нөөцийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

Хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт хийх нөхцөлийг бүрдүүлнэ.

Засгийн газрын 2005 оны 75 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЭРҮҮЛ АХУЙН
ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГДҮГЭЭР ҮЕ ШАТНЫ (2005-2007 ОН)
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах байгууллага
I. ОУХБ-ын конвенцид нэгдэн орох, олон нийтэд сурталчлах талаар		
1. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Аж үйлдвэр, худалдаан дахь хөдөлмөрийн байцаан шалгах газрын тухай 81, Хөдөлмөрийн эрүүл ахуйн албаны тухай 161 дүгээр конвенцид нэгдэн орох асуудлыг боловсруулах	2006	НХХЯ, ГХЯ, МҮЭХ, МАОЭНХ
2. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн үйлдвэрлэлийн орчны тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 155 дугаар конвенцийн орчуулгыг хянан сайжруулж, дахин хэвлүүлэх	2006-2007	НХХЯ, ГХЯ, ХЗДХЯ, МҮЭХ, МАОЭНХ
3. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн үйлдвэрлэлийн орчны тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 155 дугаар конвенцийн хэрэгжилтийн тайланг жил бүр гарган, УИХ, Хүний эрхийн үндэсний комисс, олон нийтэд мэдээлж хэвших	2006-2007	НХХЯ, ГХЯ, МҮЭХ, МАОЭНХ
4. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн үйлдвэрлэлийн орчны тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 155 дугаар конвенцийн талаар ойлголт өгөх сургалт, сурталчилгааг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах	2006-2007	НХХЯ, ГХЯ, ХЗДХЯ, МҮЭХ, МАОЭНХ, ТББ
II. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар		
5. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хуулийн төсөл боловсруулах асуудлыг судлах	2006 оноос	НХХЯ, ХЗДХЯ, МҮЭХ, МАОЭНХ
6. Нийгмийн даатгалын сангаас олгох Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг боловсруулах	2006	НХХЯ, ХЗДХЯ, СЯ
7. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогоос урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөр боловсруулж, эхний шатыг хэрэгжүүлэх	2006-2007	НХХЯ, ХЗДХЯ, СЯ, УМХГ, МҮЭХ, МАОЭНХ

8.Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартыг шинээр болон шинэчлэн боловсруулж, мөрдүүлэх	2006-2007	НХХЯ, СХЗТ
9.ОУХБ-ын Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн удирдлагын системийн удирдамж (ILO-OSH 2001)-ийг үндэслэн, аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн менежментийн систем нэвтрүүлэх удирдамж боловсруулж, үе шаттайгаар хэрэгжүүлэх	2006-2007	НХХЯ, холбогдох яамд, МҮЭХ, МАОЭНХ, ТББ
10.Уул уурхай, эрчим хүч, барилга, тээвэр, холбооны салбарын машин, тоног төхөөрөмж, аюултай бодисын аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг шинээр болон шинэчлэн боловсруулах	2006-2007	НХХЯ, холбогдох яамд, УМХГ
11.ОУХБ, ДЭМБ-ын «Силикоз өвчнийг устгах» хөтөлбөрт хамрагдах, Тоосжилтыг багасгах, урьдчилан сэргийлэх төсөл хэрэгжүүлэх	2006-2007	НХХЯ, ЭМЯ, ТЭХЯ, БХБЯ
Ш. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах талаар		
12.Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн нөхцөлийг аттестатчилах	2006-2007	НХХЯ, УМХГ, аймаг, нийслэлийн Засаг дарга, МҮЭХ, МАОЭНХ
13.Эрсдэл өндөртэй аж ахуйн нэгжүүдэд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөл гарч байгаа шалтгаан нөхцөлийг судлах	2006-2007	НХХЯ, МҮЭХ, МАОЭНХ, ТББ
14.Хөдөө аж ахуйн салбар, жижиг, дунд үйлдвэрлэл, албан бус сектор /гэрээрээ хөдөлмөр эрхлэгчид, эмэгтэйчүүд, хүүхэд, залуучууд, тахир дутуу хүмүүс/-т хөдөлмөр эрхлэгчдийн хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах асуудлыг судлах	2006-2007	НХХЯ, ХХААЯ, ҮХЯ
15.Ажлын байрны нөхцөлийн үнэлгээ хийдэг лабораторийг шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр хангах, ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх	2006-2007	УМХГ, НХХЯ
16.Мэргэжлийн өвчин судлал, эмнэлэг хөдөлмөрийн магадлал төвийг Үндэсний төв болгон өргөтгөх, амбулатори, поликлиник эмнэлэг сувиллын бүтэцтэй болгох асуудлыг боловсруулж, шийдвэрлүүлэх	2006-2007	НХХЯ, ЭМЯ
ИҮ. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн, статистик, мэдээлэл, судалгаа, шинжилгээг өргөжүүлэх талаар		
17.Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийг мэдээллээр хангах боломж бүхий мэдээллийн сүлжээ байгуулах, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах арга хэмжээ авах	2006-2007	НХХЯ, МҮЭХ, МАОЭНХ, ТББ

18.Томоохон аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллагын дэргэдэх мэдээллийн төвийг түшиглэн мэдээлэл хүргэх, сургалт явуулах арга хэмжээ авах	2006-2007	НХХЯ, МҮЭХ, МАОЭНХ, ТББ
19.Улсын хэмжээний үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний мэдээ цуглуулах, дүн шинжилгээ хийх нэгдсэн аргачиллыг Олон улсын хөдөлмөрийн байгууллагын дэмжлэгтэй боловсруулах	2006-2007	НХХЯ, ҮСГ, ОУХБ
20.Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн тодорхой асуудлаар Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран судалгаа хийж, шийдвэр гаргагчид, олон нийтэд хүргэх	2006-2007	НХХЯ, МҮЭХ, МАОЭНХ
21.Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлаар мэргэшсэн эрдэмтэн, судлаачдын хамтлагийг Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийг түшиглэн байгуулах арга хэмжээ авах	2006-2007	НХХЯ, ЭМЯ, БСШУЯ
22.Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, энэ талаархи төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн мэдээллийн сан бий болгох	2006	НХХЯ, ЭМЯ, БСШУЯ
23.Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл ипортоор оруулж ирдэг, энэ талын үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжийг дэмжих арга хэмжээ авах	2007	УМХГ, НХХЯ, МАОЭНХ, ТББ
Ү. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалт, сурталчилгааны тогтолцоо бүрдүүлэх талаар		
24.Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлаар сургалтын хөтөлбөр, ашиглахад хялбар сургалтын материал, сургагч багш нарт зориулсан аргачлал боловсруулах	2006-2007	НХХЯ, МҮЭХ, МАОЭНХ, ТББ
25.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтыг төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх	2006-2007	НХХЯ, МҮЭХ, МАОЭНХ, ТББ
26.Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх ажлын арга зүй, уг асуудлыг шийдвэрлэх практик аргуудыг эзэмшүүлэхэд чиглэгдсэн сургалтыг ажилтан, ажил олгогчдоод ажлын байран дээр нь явуулах механизм бүрдүүлэх	2006 оноос	НХХЯ, МҮЭХ, МАОЭНХ, аймаг, нийслэлийн Засаг дарга
27.Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны WISE, Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны POSITIVE хөтөлбөрийн сургалтад хамрагдах аж ахуйн нэгж, байгууллагын хүрээг өргөжүүлэх	2006 оноос	МҮЭХ, МАОЭНХ, ТББ
28.Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаархи ойлголт, мэдлэг олгох чиглэлээр бүх шатны сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгах асуудлыг боловсруулж, шийдвэрлүүлэх	2006 оноос	БСШУЯ, НХХЯ

29. Олон улсын "Үйлдвэрлэлийн ослын улмаас амь үрэгдсэн ажилтны дурсгалыг хүндэтгэх өдөр" жил бүрийн 4 дүгээр сарын 28-нд үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулж байх	Жил бүр	НХХЯ, МҮЭХ, МАОЭНХ, ТББ
30. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлаар үндэсний 7 хоногийн компани т ажил зохион байгуулж хэвшүүлэх	Жил бүр	НХХЯ, МҮЭХ, МАОЭНХ, ТББ
YI. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн бүтэц, зохион байгуулалт, хяналтыг боловсронгуй болгох талаар		
31. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яаманд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэц бий болгох асуудлыг судалж шийдвэрлүүлэх арга хэмжээ авах	2006-2007	НХХЯ, СЯ
32. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал эрхэлсэн орон нутгийн болон аж ахуйн нэгж, байгууллагын чиг үүргийг боловсронгуй болгох арга хэмжээ авах	2006-2007	НХХЯ, СЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга
33. "Эрүүл ажлын байр" санаачилгыг өрнүүлэн, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан болон тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг үнэлж, урамшуулах журам тогтоох	2006-2007	НХХЯ, МҮЭХ, МАОЭНХ, МҮХАУТ, ТББ
34. Төрийн болон олон нийтийн хяналтын зохистой хослол бүхий хөдөлмөрийн хяналтын тогтолцоо бий болгох	2006-2007	УМХГ, НХХЯ
35. Хөдөлмөрийн хяналтын үр ашиг, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн техникийн туслалцааны хэрэгцээг тодорхойлох	2006-2007	УМХГ, НХХЯ
YП. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн гурван талт түншлэлийн механизмыг үндэсний болон салбарын түвшинд бэхжүүлэх		
36. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн гурван талт үндэсний дэд хорооны гишүүдийн чадавхи бэхжүүлэх сургалт зохион байгуулах	2006-2007	НХХЯ, МҮЭХ, МАОЭНХ
37. Аймаг, нийслэлийн түвшинд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хоёр болон гурван талт салбар хороод байгуулах асуудлаар уулзалт, ярилцлага зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх	2007	НХХЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, МҮЭХ, МАОЭНХ
38. Салбарын болон аж ахуйн нэгж, байгууллагын хамтын гэрээ, хэлэлцээрт хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн менежментийн систем нэвтрүүлэх асуудлыг тусгах сургалт зохион байгуулах	2006-2007	НХХЯ, МҮЭХ, Салбарын ҮЭ-ийн холбоод